



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

᠑᠐᠑3 оны ᠐ᠪ сарын 13 өдөр

Дугаар 4/314

Мандалговь

Аймгийн Онцгой байдлын газартай гэрээ
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, 34.2, аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/171 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас урьдчилан сэргийлэх зорилгоор хийгдэж байгаа “Аймгийн гамшгаас хамгаалах албад, тусгай зориулалтын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд бэлэн байдлын үзлэг дадлага, сургалт”-ыг аймгийн Онцгой байдлын газраар гүйцэтгүүлсүгэй.

2. Арга хэмжээг зохион байгуулахад аймгийн Онцгой байдлын газарт шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлж хамтран ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Доржбат)-д үүрэг болгосугай.

3. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 17,575,000 (арван долоон сая таван зуун далан таван мянга) төгрөгийг аймгийн 2023 оны Орон нутгийн хөрөнгө оруулалтын хөрөнгөөр санхүүжих Гамшгийн эрсдлийн санхүүжилт арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхтайван)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ



4823100-40